



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХАРХОРИН ХОТЫН ЗАХИРАГЧИЙН  
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/91

Хархорин

Дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5, 9.6, 9.7, 9.8 дахь заалт, аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн “Мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малыг цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай” А/439 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малыг цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг хийж гүйцэтгэх, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Лхагвасүрэн (Засаг даргын орлогч)

Гишүүд: Ц.Пүрвээ (“Дэлийн бүрд” мал эмнэлгийн захирал)  
А.Сайнбилэг (“Аяган зураа” мал эмнэлгийн захирал)  
Т.Алтангэрэл (1 дүгээр багийн Засаг дарга)  
Р.Сүхбат (2 дугаар багийн Засаг дарга)  
Д.Батчулуун (3 дугаар багийн Засаг дарга)  
Г.Отгонбаяр (4 дүгээр багийн Засаг дарга)  
Б.Ганхуяг (5 дугаар багийн Засаг дарга)  
Л.Төгөлдөр (6 дугаар багийн Засаг дарга)  
О.Батсүх (7 дугаар багийн Засаг дарга)  
П.Нэндарам (8 дугаар багийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: Э.Нарангарав (Мал эмнэлгийн тасгийн дарга)

2. Мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малыг цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн 20 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулсугай.

3. Дархлаажуулалтын товыг малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч нарт зарлан мэдээлж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Товлосон хугацаанд мал, амьтныг бэлэн байлгаж, бүрэн хамруулж, барьж бэхлэн, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдүүлэх, малын эмчийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг малчин, мал бүхий иргэдэд үүрэг болгосугай.

401100181

5. Мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малыг цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг батлагдсан хуваарийн дагуу, технологит хугацаанд нь шуурхай зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаж, ажлын явц үр дүнд хяналт тавьж ажиллахыг мал эмнэлгийн тасгийн дарга (Э.Нарангарав)-д даалгасугай.

ДАРГА



Г.ОДГЭРЭЛ